



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/652

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсан "Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Мөрөн сум, 2 дугаар цэцэрлэг"-ийн барилгын "ажлын гүйцэтгэл"-ийн төсвөөс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг хавсралтад заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжих төсөл арга хэмжээний зураг, төслийн даалгавар, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Мөрөн сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны 12-  
дүгээр сарын 29-ний өдрийн  
А/652 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН  
ЖАГСААЛТАД ТУСГАГДСАН “ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 150 ОР /ХӨВСГӨЛ,  
МӨРӨН СУМ, 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ”-ИЙН БАРИЛГЫН “АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-  
ИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Мөрөн сумын 2-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах /150 хүүхэд /	45,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	45,000,000	